

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn
Гүйцэтгэсэн аудитор: Л.Оюунчимэг
Утас: 99142061
Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ДАВААЖАВ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 25 № 1/265
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 18,056.3 мянган төгрөгийн 6ш зөөврийн компьютер, 1ш ухаалаг телевизорыг машин тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Аудитаар нягтлан бодох бүртгэл, төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 7,578.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч, 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилт 72.1 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

672502188

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>153,669,329.56</u>	<u>136,723,824.99</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	98,988,376.98	78,057,254.09
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	98,988,376.98	78,057,254.09
3121	Төгрөг	98,988,376.98	78,057,254.09
31211	Төрийн сангийн харилцах	98,988,376.98	78,057,254.09
33	АВЛАГА	00.00	1,378,156.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,378,156.10
35	БАРАА МАТЕРИАЛ	54,680,953.58	57,288,414.80
351	Түүхий эд материал	1,237,700.00	1,561,521.00
35110	Тусгай зориулалттай материал	72,000.00	
35130	Эм боох материал	1,165,700.00	1,561,521.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,210,505.10	9,665,305.10
354	Хангамжийн материал	46,323,748.48	46,061,588.70
35410	Бичиг хэргийн материал	111,100.00	252,100.00
35420	Аж ахуйн материал	28,710,920.00	27,047,020.00
35440	Түлш, шатах тослох материал	1,295,000.00	
35450	Барилгын засварын материал	1,427,000.00	4,919,250.00
35460	Хүнсний материал	14,156,328.48	13,310,818.70
35470	Бусад хангамжийн материал	532,400.00	532,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>989,456,195.75</u>	<u>1,003,685,987.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	989,456,195.75	1,003,685,987.83
392	Биет хөрөнгө	965,728,195.75	979,957,987.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,112,189,086.00	1,112,189,086.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-169,351,907.91	-196,169,455.35
39203	Авто тээврийн хэрэгсэл		23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-391,666.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,940,960.00	60,896,705.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,070,535.43	-26,723,756.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,644,327.61	21,355,105.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,884,184.68	-18,780,480.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,343,097.00	5,450,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,355,096.84	-1,640,000.00
39217	Ном	272,450.00	272,450.00
393	Биет бус хөрөнгө	<u>23,728,000.00</u>	<u>23,728,000.00</u>
39301	Програм хангамж	00.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,728,000.00	23,728,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,143,125,525.31</u>	<u>1,140,409,812.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

413	Өглөг	00.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	00.00
4136	Бусад өглөг	00.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,143,125,525.31</u>	<u>1,140,409,812.82</u>
51	Засгийн газрын хувь өрөлцөө	1,143,125,525.31	1,140,409,812.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,534,205.00	94,534,205.00
51101	Өмч: - төрийн	94,534,205.00	94,534,205.00
512	Хуримтлагдсан үр дүн	958,967,351.23	956,251,638.74
51210	Өмнөх үеийн үр дүн	958,967,351.23	958,967,351.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,715,712.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,623,969.08	89,623,969.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,143,125,525.31</u>	<u>1,140,409,812.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	529,568,600.00	777,886,195.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	51,437,795.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	51,437,795.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	44,108,395.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - УХ		44,108,395.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – БМ	00.00	7,329,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,533,600.00	726,448,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	499,533,600.00	686,448,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	499,533,600.00	686,448,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,000,000.00	40,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,000,000.00	40,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	509,798,721.44	778,409,007.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,798,721.44	778,409,007.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,429,141.55	776,843,280.55
2101	Цалин хөлс бөлөн нэмэгдэл урамшил	340,308,274.37	565,068,165.79
210101	Үндсэн цалин	340,308,274.37	369,415,279.17
210102	Нэмэгдэл	00.00	174,881,095.37
210104	Урамшуулал	00.00	20,771,791.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,147,895.60	72,163,600.00
210201	Тэтгэврийн даатгал	42,989,095.60	49,071,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	5,773,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,886,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,886,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	158,800.00	11,546,200.00

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,285,420.11	30,350,873.06
210301	Гэрэл, цахилгаан	3,716,010.11	4,934,273.06
210302	Түлш, халаалт	21,405,000.00	21,916,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,164,410.00	3,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,616,049.73	11,752,029.00
210401	Бичиг хэрэг	1,085,549.73	4,949,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,814,870.00	3,265,379.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,715,630.00	3,536,700.00
2105	Нормативт зардал	44,017,245.18	44,204,109.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	187,866.00	129,000.00
210502	Хоол, хүнс	43,829,379.18	44,075,109.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,840,500.00	9,151,250.00
210604	Урсгал засвар	3,840,500.00	9,151,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,000.00	1,386,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	630,000.00	1,386,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,583,756.56	42,767,252.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,967,000.00	3,908,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,589,500.00	1,870,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,027,256.56	36,987,952.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,369,579.89	1,565,726.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,369,579.89	1,565,726.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,369,579.89	1,565,726.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19,769,878.56	-522812.49
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	2,192,900.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	2,192,900.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,192,900.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,192,900.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19,769,878.56	-2,715,712.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	972,574,676.44	1,156,732,850.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	972,574,676.44	1,156,732,850.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,598,703.42	-6,598,703.42
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	958,967,351.23	1,143,125,525.31

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	958,967,351.23	1,143,125,525.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	958,967,351.23	1,143,125,525.31
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,715,712.49	-2,715,712.49
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,534,205.00	89,623,969.08	957,817,365.68	1,140,409,812.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	529,568,600.00	726,483,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,533,600.00	726,448,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	499,533,600.00	686,448,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	499,533,600.00	686,448,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,000,000.00	40,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,000,000.00	40,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	483,179,891.85	743,516,794.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,179,891.85	743,516,794.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	480,810,311.96	743,516,794.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,510,286.06	566,446,321.89
210101	Үндсэн цалин	241,814,048.80	369,415,279.17
210102	Нэмэгдэл	77,408,914.64	176,259,251.47
210104	Урамшуулал	15,287,322.62	20,771,791.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,329,205.79	72,163,600.00
210201	Тэтгэврийн даатгал	32,274,533.87	49,071,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,038,288.00	5,773,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,207,970.43	2,886,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	787,437.35	2,886,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,020,976.14	11,546,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,880,420.11	28,434,273.06

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	3,716,010.11	4,934,273.06
210302	Түлш, халаалт	18,000,000.00	20,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,164,410.00	3,500,000.00
2105	Нормативт зардал	53,482,000.00	43,229,600.00
210502	Хоол, хүнс	53,482,000.00	43,229,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	8,350,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	8,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,000.00	1,586,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	735,000.00	1,586,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,873,400.00	23,306,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,580,000.00	18,490,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,293,400.00	4,815,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,369,579.89	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,369,579.89	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,369,579.89	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	46,388,708.15	-17,033,394.95
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46,388,708.15	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,349,667.83	98,988,375.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,988,375.98	79,622,981.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (улсын төсөв)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	105,152,037.53	(105,152,037.53)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	785,118,100.00	707,414,521.89	82,733,578.11	81.82
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	785,118,100.00	707,414,521.89	82,733,578.11	81.82
Бараа, үйлчилгээний зардал	785,118,100.00	707,414,521.89	82,733,578.11	81.82
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,859,800.00	566,446,321.89	69,413,478.11	84.78
Үндсэн цалин	427,637,200.00	369,415,279.17	58,221,920.83	83.95
Нэмэгдэл	199,149,800.00	176,259,251.47	22,890,548.53	85.44
Урамшуулал	9,072,800.00	20,771,791.25	(11,698,991.25)	102.28
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,517,000.00	72,163,600.00	2,353,400.00	84.85
Тэтгэврийн даатгал	50,672,900.00	49,071,300.00	1,601,600.00	77.77
Тэтгэмжийн даатгал	5,960,100.00	5,773,100.00	187,000.00	95.43
ҮОМШӨ ний даатгал	2,980,600.00	2,886,500.00	94,100	131.30
Ажилгүйдлийн даатгал	2,980,600.00	2,886,500.00	94,100	95.40
Эрүүл мэндийн даатгал	11,922,800.00	11,546,200.00	376,600.00	95.40
Нормативт зардал	47,207,600.00	43,229,600.00	3,978,000.00	57.26
Хоол, хүнс	47,207,600.00	43,229,600.00	3,978,000.00	57.26
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,586,400.00	1,586,400.00	00.00	100
Мэдээллийн технологийн зардал	1,586,400.00	1,586,400.00	00.00	100
Бараа үйлчилгээний бусад зардал	25,947,300.00	18,958,600.00	6,988,700.00	61.26
Бараа үйлчилгээний бусад зардал	20,449,400.00	18,490,700.00	6,988,700.00	66.25

Аудитын код: ХӨА-2025/164/НА-СТА-ТЗШ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	5,497,900.00	5,497,900	00.00	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	785,118,100.00	686,483,400.00	105,216,800.00	85.95
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	785,118,100.00	686,483,400.00	99,900.00	99.98
Улсын төсвөөс санхүүжих	785,118,100.00	686,483,400.00	99,900.00	99.98
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	785,118,100.00	686,483,400.00	105,116,900.00	0.10
Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00		-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00		-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98,669,700.00	98,988,375.98		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	98,988,375.98	(98,988,375.98)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	78,057,254.09	(78,057,254.09)	-

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (орон нутгийн төсөв)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,000,000.00	38,434,273.06	1,565,726.94	95.76
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	40,000,000.00	38,434,273.06	1,565,726.94	95.76
Бараа, үйлчилгээний зардал	40,000,000.00	38,434,273.06	1,565,726.94	95.76
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,000,000.00	22,873,931.94	1,565,726.94	94.91
Гэрэл цахилгаан	6,500,000.00	4,934,273.06	1,565,726.94	85.59
Түлш, халаалт	20,000,000.00	20,000,000.00	00.00	100.00
Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,500,000.00	00.00	100.00
Эд хогшил худалдан авах	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.00
Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,000,000.00	40,000,000.00	00.00	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,000,000.00	40,000,000.00	00.00	100.00
Орон нутгийн төсвөөс	40,000,000.00	40,000,000.00	00.00	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,565,726.94	(1,565,726.94)	-

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 7,578.0 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 6 зөвлөмж хүргүүлж 1 асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудалд шилжүүлэв.

5.1 Аудитын залруулга

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Албан шаардлага тогтоогоогүй.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Аудитын код: ХӨА-2025/164/НА-СТА-ТЗШ

Илрүүлэлт 1:

Төсвийн захирагч нь 6 багш ажилтанд нийт 4.1 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа нэмэгдэл хөлс тооцож олгох батлагдсан маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4 дэхь заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Илүү цагийг тооцож олгохдоо Засгийн газрын "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгт хөтлөх

Илрүүлэлт 2:

Ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу багш нарын ур чадварыг үнэлэх ажлын хэсэг байгуулж, ажлыг үнэлсэн баримтгүйгээр төсөв захирагчийн 10 удаагийн тушаалаар 16 багш, ажилтанд нийт 14.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/85, А/10/9 дүгээр хамтарсан тушаалтай заалттай нийцэхгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдлийг олгохдоо төсөв захирагчийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан, үнэлэх

Илрүүлэлт 3:

Тус сургууль өөрийн ажил үйлчилгээний онцлогт нийцүүлэн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоогоогүй, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө спидометрийн заалтыг бичээгүй, багш ажилтнуудад аймаг улсын чанартай тэмцээн уралдаан, сургалт семинарт оролцоход шатахууныг төсвийн захирагчийн албан бичгээр олгож нийт 36 багш, ажилтанд 3,0 мянган төгрөгийн шатахууныг тооцоо бодолгүйгээр зарцуулсан байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалтай нийцээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөж жишиг нормыг баталж ажиллах

2. Тус цэцэрлэг нь тайлант онд "БНУЧЧ" ХХК-тай хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээ байгуулж, гэрээнд заасан хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс 2,998.0 мянган төгрөгийн үнэ бүхий 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг илүү, 5 нэр төрлийн бүтээгдэхүүнийг огт нийлүүлээгүй, гэрээгүй нийт 694.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх"-т заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жолоочийн тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан байна.	1	3,886.0					1	3,886.0
Худалдан авах гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг баримтлаагүй зөрчил илэрсэн.	1	3,692.0					1	3,692.0
Актлагдсан хөрөнгийн устгалын актыг тооллогын комисс хийсэн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө тайлан, хурлын тэмдэглэлгүй	1						1	
Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас хөтлөхгүйгээр нийт 6 багшид 4.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон	1						1	
Үнэлгээний баг томилохгүйгээр төсөв захирагчийн 9 удаагийн тушаалаар 16 багш, ажилтны ур чадварын нэмэгдэлд нийт 14.1 мянган төгрөгийг олгосон.	1						1	
Тус цэцэрлэгийн эрхлэгчийн "Балансын урамшуулал олгох тухай" 2024 оны Б/39 дүгээр тушаалаар нягтлан бодогчид 2 сар, няравт 1 сарын үндсэн цалингаар тус тус балансын урамшуулалд 3.6 сая төгрөгийг төсвийн зарлагын эдийн ангилал зөрүүтэй зарцуулсан	1						1	
Дүн	6	7,578.0					6	7,578.0